



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Мал, амьтаны зарим халдварт өвчнөөс  
урьдчилан сэргийлэх, хорогдсон мал, амьтны  
сэг зэм цуглуулж устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1 дэх дэд заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/419 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Мал, амьтны зарим халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн үйл ажиллагааг чанар үр дүнтэй хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, сэг зэмийн устгалын ажлыг зохион байгуулахад шаардлагатай машин техникээр хангаж ажиллахыг "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ (Ч.Батхуяг)-т, Багахангай тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа)-т, хүн хүчээр хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т, тус ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Б.Батмөнх)-т тус тус үүрэг болгосугай.

3.Мал, амьтны сэг зэм цуглуулж устгах, халдваргүйтгэл хийх арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

4.Шаардагдах 1.127.840 (Нэг сая нэг зуун хорин долоо мянга найман зуун дөх) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

1123240225

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 04 сарын 17-ны өдрийн 163 дугаар  
захирамжийн хавсралт



МАЛ, АМЬТНЫ ЗАРИМ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХОРОГДСОН МАЛ, АМЬТНЫ  
СЭГ ЗЭМ ЦУГЛУУЛЖ УСТГАХ ТУХАЙ

| №    | Хийгдэх ажил                                                 | Зардлын нэр  | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт      |
|------|--------------------------------------------------------------|--------------|-------------|--------|----------------|-----------|
| 1    | Сэг зэмийн тархцыг судлах, хяналт хийхэд шаардагдах шатахуун | АИ-92        | литр        | 24     | 2410           | 57.840    |
| 2    | Сэг зэмийг цуглуулахад шаардагдах шатахуун (3 өдрийн)        | Дизель түлш  | литр        | 200    | 3750           | 750.000   |
| 3    | Өдрийн хоол                                                  | 2 өдөр 8 хүн | Хүн/өдөр    | 16     | 20000          | 320.000   |
| Нийт |                                                              |              |             |        |                | 1.127.840 |